



БАТЛАВ
АЙМГИЙН ЗАСАГДАРГА
Д.МӨНХСАЙХАН
Огноо.....

ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬД СУРАЛЦАХ ОЮУТАНТАЙ БАЙГУУЛАХ ГЭРЭЭ

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү гэрээг Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрыг төлөөлж Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /цаашид АЗДТГ гэнэ/, Хүнс хөдөө аж ахуйн газрыг төлөөлж /цаашид ХХААГ гэнэ/ Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга, сумын Засаг даргын Тамгын газрыг төлөөлж Засаг даргын Тамгын газрын дарга /цаашид СЗДТГ гэнэ/, суралцагч талыг /цаашид оюутан гэнэ/ төлөөлж аймгийн сургалтын тэтгэлэгт хөтөлбөрөөр суралцагч..... кодтой Баатарсүрэн овогтой Тулгабадам нар харилцан тохирч, Монгол Улсын Иргэний хууль, Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, бусад холбогдох дүрэм, журмыг үндэслэн байгуулав.

ХОЁР. АЗДТГ -ЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 2.1. Сургуулийн захиргаанаас албан ёсоор мэдэгдсэнээр оюутны сургалтын төлбөрийн 50%-ийг бүрэлдэхүүн сургуулийн дансанд баримтыг үндэслэн шилжүүлнэ.
- 2.2. Суралцах гэрээг жил бүр шинэчлэн байгуулж, сунгалт хийх

ГУРАВ. ХХААГ -ЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 3.1. Бүрэлдэхүүн сургуулийн удирдлагатай байнгын холбоотой ажиллаж, сургалтын төлөвлөгөөнд заагдсан хичээлүүдийг бүрэн судалж, эзэмшиж байгаад хяналт тавих
- 3.2. Сургалт, үйлдвэрлэлийн дадлагыг тухайн орон нутагт нь хийлгэх

ДӨРӨВ. СУМЫН ЗДТГ-ЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 4.1. Бүрэлдэхүүн сургуулийн удирдлагатай байнгын холбоотой ажиллаж, сургалтын төлөвлөгөөнд заагдсан хичээлүүдийг бүрэн судалж, эзэмшиж байгаад хяналт тавих
- 4.2. Суралцагчийг ажлын байраар ханган Засгийн газраас тогтоосон цалингийн сүлжээгээр цалинжуулах.
- 4.3. Танхимаар суралцахаар явах хугацаанд цалинтай чөлөө олгоно.
- 4.4. Сургалт, үйлдвэрлэлийн дадлагыг тухайн орон нутагт нь хийлгэх

ТАВ. АЗДТГ, ХХААГ, СЗДТГ -ЫН ЭРХ

- 5.1. Оюутнуудаас суралцах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах
- 5.2. Оюутны гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, сургалтын төлөвлөгөөнд заагдсан хичээлүүдийг бүрэн эзэмшиж судлаагүй, гэмт хэрэг хэв журмын зөрчил гаргасан, сургуулийн дотоод журам бусад холбогдох дүрэм, журам зөрчсөн, хүндэтгэх шалтгаангүйгээр /эрүүл мэнд, суралцагч нас барсан/ суралцах явцад сургуулиа орхисон тохиолдолд сургалтын төлбөрийг шилжүүлэхгүй буюу тухайн оюутнаар бүрэн төлүүлнэ.
- 5.3. Сургалтын төлөвлөгөөнд заагдсан хичээлүүдийг бүрэн судалж, мэргэжил эзэмшсэн тохиолдолд тухайн сумд нь хуваарилан ажиллуулна.
- 5.4. Оюутан хангалтгүй дүн үзүүлсэн тохиолдолд тухайн хичээлийн багц цагийн төлбөрийг төлөхгүй
- 5.5 ХХААГ нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх талаар гэрээнд оролцогч талуудаас шаардах

ЗУРГАА. ОЮУТНЫ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 6.1 Сургалтын төлбөрийг хичээлийн жилд, улирал бүрийн эхэнд бүрэн төлүүлэх талаар АЗДТГ, СЗДТГ -т хүсэлт өгөх,
Сургуулийн захиргаанаас албан ёсоор мэдэгдсэнээр сургалтын төлбөрийнхөө 50%-ийг бүрэлдэхүүн сургуулийн дансанд шилжүүлэх.

- 6.2 Сургалтын төлөвлөгөөнд заагдсан хичээлүүдийг бүрэн үзэж, зохих багц цагийг цуглуулах.
- 6.3 АЗДТГ, ХХААГ, СЗДТГ, Сургуулийн захиргаа сургалтын албанаас гаргасан тушаал шийдвэр, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх.
- 6.4 Оюутан хангалтгүй дүн үзүүлсэн тохиолдолд тухайн хичээлийн багц цагийн төлбөрийг оюутан өөрөө бүрэн төлж дахин судлах.
- 6.5 Явцын болон улирлын шалгалт, сургалт, үйлдвэрлэлийн дадлага, төгсөлтийн ажлыг цаг хугацаанд өгч хамгаалах
- 6.6 Улирлын эцэст судалсан хичээлүүдийн дүнг баталгаажуулах.
- Сургуулиа төгсөж мэргэжлийн үнэмлэхээ авсан тохиолдолд тухайн орон нутагтаа эзэмшсэн мэргэжилээр 5-аас дээш жил тогтвор суурьшилтай ажиллах
- 6.7 Төрийн албаны ерөнхий шалгалтад заавал орж тэнцэнэ.

ДОЛОО. ОЮУТНЫ ЭРХ

- 7.1 Хэвийн суралцах бололцоогоор хангуулах, боловсролын зэргээ ахиулах,
- 7.2 Сургалтын төлөвлөгөөн дэх заавал судлах хичээлээс гадна сонгон хичээлүүдийг судлах
- 7.3 Сургалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй хичээлийг сонгон судлах тохиолдолд нэмэлт төлбөрийг өөрөө төлж суралцах
- 7.4 ХААИС болон багшийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар санал гаргах, шүүмжлэх, шаардлага тавих эрхтэй
- 7.5 Хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хөнгөлөлт эдлэх,
- 7.6 Оюутны хөгжил, дэвшилд чиглэсэн үйл ажиллагаа, хөтөлбөрт хамрагдах эрхтэй

НАЙМ. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ НӨХЦӨЛ

- 8.1. АЗДТГ, ХХААГ, СЗДТГ, Сургуулийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг удаа дараа биелүүлээгүй, дотоод журам болон холбогдох дүрэм журмын заалтыг зөрчсөн тохиолдолд цуцлана.
- 8.2. ХААИС -аас "Анхааруулах хуудас" 2 удаа авсан тохиолдолд сурлагаар тэнцээгүйд тооцож гэрээг цуцлана
- 8.3 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд төлбөрийг 100 хувь оюутнаар төлүүлнэ.

ЕС. ГЭРЭЭНИЙ ХҮЧИНТЭЙ БАЙХ ХУГАЦАА

- 9.1 АЗДТГ, ХХААГ, СЗДТГ, суралцагч нь гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд учирсан гэм хорыг зохих хууль, дүрэм, журмын дагуу арилгана.
- 9.2. Энэхүү гэрээг талууд тус бүр нэг хувь хадгална.
- 9.3. Энэ гэрээнд 4 тал гарын үсэг зурсан өдрөөс эхлэн нэг жилийн хугацаанд хүчинтэй бөгөөд гэрээний бүх нөхцөл хангагдаж 4 тал тохиролцвол цаашид жил, жилээр сунгаж болно.
- 9.4. Гэрээнээс үүссэн маргааныг 4 тал харилцан тохиролцож чадаагүй тохиолдолд хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
 ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:
 НИЙГМИЙН БОДЛОГИЙН ХЭЛТСИЙН
 ДАРГА *[Signature]* Б.НАРАНБЯАР
 СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
 ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:
 ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
[Signature] Д.ОТГОНЖАРГАЛ

АЙМГИЙН ХҮНС ХӨДӨӨ АЖ ГАЗРЫГ
 ТӨЛӨӨЛЖ:
 ХХААГАЗРЫН ДАРГА
[Signature] Ж.БАТТӨР
 СУРАЛЦАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
 ОЮУТАН
[Signature] Б.ТУЛГАБАДАМ